

ДИЗЕЛИЙН ТҮЛШ - ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий үзүүлэлт:

Монгол улсын **MNS 0216 : 2017** стандартын шаардлага хангасан байх.

Зориулалт:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын “Монголросцветмет” ТӨҮГ-н харъяа “Бор-Өндөр” УБҮ-т ашиглагдаж буй дизелийн түлшээр ажилладаг хөдөлгүүртэй тээврийн хэрэгслүүд болон бусад зориулалтын ижил төрлийн хөдөлгүүрүүд ажиллахад зориулагдана.

Тоо хэмжээ:

Өвлийн түлш: 3,532,000 /гурван сая таван зуун гучин хоёр мянга/ килограмм.
Зуны түлш: 2,523,000 /хоёр сая таван зуун хорин гурван мянга/ килограмм.

Шатахуун нь дараах үндсэн шаардлага хангасан байна. Үүнд:

1. Түлш шатахуун нь олон улсын стандартад нийцсэн байна. Авто шатахуун нь ОХУ –ын **ГОСТ 32511-2013** стандартын дагуу үйлдвэрлэгдсэн, нийлүүлэх Евро дизелийн түлш Монгол улсын **MNS 0216 : 2017** стандартыг хангасан байх, стандартчилал хэмжил зүйн тохирлын гэрчилгээ, магадлан итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээнд хамрагдсан байна.
2. Нийлүүлэгч байгууллага нь шатахуун, шатах тослох материалын “Итгэмжлэгдсэн лаборатори”–той байх ба бүтээгдэхүүнүүд нь зохих хугацаанд шинжилгээнд хамрагдаж баталгаажсан байх.
3. Нийлүүлэгч нь шатахуун, шатах тослох материал худалдах тусгай зөвшөөрөлтэй, албан ёсны гэрээт борлуулагч байх бөгөөд Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн аймаг, сумын төвд шатахуун түгээх салбар, сүлжээтэй байна.
4. Зах зээлд шатахууны хомсдол үүссэн нөхцөлд нийлүүлэгч тал гэрээний үйл ажиллагааг тасралтгүй ханган ажиллах бөгөөд шатахууны нөөцийг орон нутагт бүрдүүлсэн байна.
5. Тухайн шатахууныг үйлдвэрлэгч, зуучлан борлуулагч буюу нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хуулбар, барааны чанарын сертификат, итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээний дүгнэлтийг заавал хавсаргана.
6. Улаанбаатар хотоос аймгийн төвүүд болон аймаг хоорондын улсын чанартай төв зам дагуу шатахуун түгээх станцуудтай байна. Бүх ШТС-ын байршил, сүлжээ схем зураглал тодорхой байх.
7. Нийлүүлэгч нь Улаанбаатар хот, Говьсүмбэр аймаг, Багануур дүүрэг, Дорноговь аймагт өөрийн эзэмшлийн агуулахтай байх.
8. Дизелийн түлшний гадаад шинж чанар:
 - Шатамхай
 - Сав баглаа боодол
 - Гадаад байдал
 - Ашиглах температур:
 - Зуны түлш
 - Өвлийн түлш
 - Экологийн ангилал
 - Үйлдвэрлэсэн он
 - Задгай
 - Шингэн төлөвтэй
 - -5°C - аас дээш
 - -35°C - $+0^{\circ}\text{C}$
 - K2
 - 2023 оноос хойш

9. Дизель түлшний техникийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлтийн нэр	Нэгж	Аргачлал	Норм стандарт
1	Хувийн жин	г/см ³	MNS 480-83	0,800-0,860
2	Найрлагын бүрэлдэхүүн: 50% 96%	С	ISO MNS 3405- 2000	240-280 330-360
3	Булингартах температур	С	MNS 3594-83	-5- -25
4	Царцах температур	С	MNS 3594-83	-10 -40
5	Зэс хавтгайн туршилт	С	MNS 326-85	Тэсвэртэй
6	Усанд уусдаг хүчил шүлт	%	MNS 324-84	Байхгүй
7	Усны хэмжээ	%	MNS 332-96	Байхгүй
8	Механик хольцын хэмжээ	%	MNS 322-84	Байхгүй
9	Өнгө	%	ISO MNS 2049- 2000	Тодорхойлно
10	Кинаметик зууралдлага	мм/сек	MNS 328-2000	1,5-6,0
11	Битүү тигельд дөл үүсэх температур	С	С MNS 333-83	30-45
12	Давирхайн хэмжээ	%	MNS 477-96	30-40
13	Үнсжилт	%	MNS 3501-83	0.01

10. Нийлүүлэх хугацаа: Гэрээний хавсралтын дагуу